МЭДЭЭ · 2022 оны 7-р сарын 10

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР Б.ЖАРГАЛСАЙХАН БАЯР НААДМЫН МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЛЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР



Мэндчилгээ

Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол Улс байгуулагдсаны 815, 816, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, 111, Ардын хувьсгалын 100, 101 жилийн ой, Үндэсний их баяр наадмын мэндчилгээг Прокурорын байгууллагын үе үеийн ахмадууд, нийт прокурор, ажилтнууд Та бүхэндээ өргөн дэвшүүлье.

Төрийнхөө төлөө өргөсөн тангараг, түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, шударга үнэний төлөө зогсолтгүй зүтгэж буй эрхэм прокурор, ажилтнууд Та бүхэн минь хүлэг морьдын төвөргөөнд сүлд хийморио сэргээж, хүчит бөхчүүдийн уран мэхэнд хараа мэлмийгээ баясгаж, хасаа сурын оноонд сэтгэл дэврэн хурайлж, хамаг олон бүлээрээ төвшин сайхан наадаарай.

Төрт ёсоо дээдлэх
Түмэн олны их цэнгэл
Өрөвл бусдаас танигдах
Өвгөд дээдсийн их соёл
Үндэсний их баяраараа сайхан наадаарай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2022 оны 7 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2275